



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэг 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОУЭБ	Олон улсын эвлэлийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН 7 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ О.ЭНХЖАРГАЛ ТАНАА

О.Энхжаргал № *125*
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын үнэлгээний төвийн сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн үнэлгээгээр 1 дүгээр шатлалд шалгарч 15,773.4 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 94,794.8 мянган төгрөг, ажил олгогч нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,917.7 мянган төгрөг, хоолны зардал 549.4 төгрөг, эрүүл мэндийг дэмжих зардал 2,427.0 төгрөг, нормативт зардал 9.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 55.2 мянган төгрөгийг хэмнэснээс зарцуулагдаагүй 100,754.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр БШУГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Өцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,513,286.85	238,876,632.60
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8,550,589.24	100,754,121.16
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа	8,550,589.24	100,754,121.16
3121	Төгрөг	8,550,589.24	100,754,121.16
31211	Төрийн сангийн харилцах	8,550,589.24	100,754,121.16
35	БАРАА МАТЕРИАЛ	102,962,697.61	138,122,511.44
351	Түүхий эд материал	4,076,392.05	7,544,433.59
35130	Эм боох материал	4,076,392.05	7,544,433.59
354	Хангамжийн материал	98,886,305.56	130,578,077.85
35410	Бичиг хэргийн материал	4,257,625.23	12,310,205.23
35420	Аж ахуйн материал	67,857,745.17	83,682,807.17
35440	Түлш шатах тослох материал	15,640.00	
35460	Хүнсний материал	5,580,006.00	2,993,276.29
35470	Бусад хангамжийн материал	21,175,289.16	31,591,789.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,795,491,815.65	1,868,640,030.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,795,491,815.65	1,868,640,030.23
392	Биет хөрөнгийн дүн	1,500,130,955.52	1,573,504,030.03
39201	Барилга байгууламж	1,418,218,597.00	1,418,218,597.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(181,965,654.61)	(227,441,177.77)
39217	Тээврийн хэрэгсэл	44,500,000.00	44,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,012,499.91)	(14,462,499.87)
39205	Машин тоног төхөөрөмж	114,656,682.41	231,550,188.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,022,371.94)	(73,883,204.36)
39207	Тавилга, эд хогшил	143,547,165.50	229,290,055.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,621,787.75)	(59,416,006.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,713,403.94	33,713,403.94
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,882,579.12)	(8,565,326.40)
393	Биет бус хөрөнгийн дүн	295,360,860.13	295,136,000.20
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хасагдуулга	(899,439.87)	(1,124,299.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	295,136,000.00	295,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,907,005,102.50	2,107,516,662.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,907,005,113.53	257,623,955.78
51	Засгийн газрын хувь оролцоо	1,907,005,113.53	2,107,516,662.83
511	Засгийн газрын оруулсан капитал	295,136,000.00	295,136,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	960,509,676.79	1,161,021,226.09
51210	Өмнөх үеийн үр дүн	960,509,676.79	960,509,676.79
51220	Тайлант үеийн үр дүн		200,511,549.30
51300	Дахин үнэлгээний зөрүү	651,359,436.74	651,359,436.74
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	1,907,005,102.50	2,107,516,662.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,150,467,913.00	1,580,826,536.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	216,136,967.00	268,123,436.00
120	Нийтлэг татварын бус орлого	216,136,967.00	268,123,436.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	157,781,100.00	51,535,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		51,535,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	157,781,100.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,929,000.00	186,191,946.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	55,426,867.00	30,396,490.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,330,946.00	1,312,703,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	858,148,500.00	1,265,040,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	858,148,500.00	1,265,040,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,182,341.00	47,663,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,182,341.00	47,663,000.00
2	Үйл ажиллагааны зардал	1,046,319,825.52	1,380,314,986.70
21	Урсгал зардал	1,046,319,825.52	1,380,314,986.70
210	Бараа, үйлчилгээний зардал	1,039,516,493.52	1,364,531,678.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	640,314,340.76	865,660,180.14
210101	Үндсэн цалин	426,702,695.76	597,652,441.79
210102	Нэмэгдэл цалин	158,310,421.00	237,202,007.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	32,779,392.00	30,805,731.00
210105	Гэрээтийн цалин		-
210106	Гэрээт ажлын хөлс	22,521,832.00	
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	81,437,562.00	115,457,930.60
210201	Тэтгэврийн даатгалын	55,803,381.30	78,687,008.77
210202	тэтгэмжийн даатгалын	6,565,082.59	9,228,103.92
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,174,747.23	7,369,163.14
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,263,150.09	1,851,831.96
210205	ЭМ-ийн даатгалын	12,631,200.79	18,321,822.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,833,368.00	45,340,592.19
210301	Гэрэл цахилгааны зардал	5,457,246.00	8,717,729.09
210302	Түлш, халаалтын зардал	21,088,688.00	25,527,516.78
210303	Цэвэр бохир усны зардал	12,287,434.00	11,095,346.32
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	43,657,427.21	34,697,619.00

210401	Бичиг хэргийн зардал	5,743,360.00	6,006,799.00
210404	Тээвэр шатахуун	6,338,850.00	8,123,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	10,890.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	28,832,944.00	20,567,180.00
210408	Бараа материал акталсны зардал	2,731,383.21	
2105	Нормативт зардал	104,602,846.00	160,175,795.51
210500	Эд хогшил, урсгал засварын зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,206,205.00	501,258.46
210502	Хоол, хүнс	103,396,641.00	159,674,537.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,006,467.00	-
210604	Урсгал засварын зардал	50,006,467.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,560,800.00	1,962,400.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,560,800.00	1,962,400.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	79,103,682.55	141,237,161.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,412,390.00	11,548,980.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	240,000.00	200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,451,292.55	129,488,181.45
213	Урсгал шилжүүлэг	6,803,332.00	15,783,307.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,337,200.00	15,773,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,337,200.00	15,773,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	466,132.00	9,907.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	466,132.00	9,907.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	
3	Үйл ажиллагааны үр дүн	104,148,087.48	200,511,549.30
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	104,148,087.48	200,511,549.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан өг.
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	934,330,946.00	1,364,238,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		51,535,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	51,535,000.00
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	51,535,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		51,535,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934,330,946.00	1,312,703,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	858,148,500.00	1,265,040,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	858,148,500.00	1,265,040,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	-	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,182,341.00	47,663,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,182,341.00	47,663,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	918,134,256.76	1,257,210,118.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	918,134,256.76	1,257,210,118.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	911,330,924.76	1,241,426,810.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	640,314,340.76	865,660,180.14
210101	Үндсэн цалин	441,273,976.76	597,652,441.79
210102	Нэмэгдэл	149,926,604.00	237,202,007.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	29,349,360.00	30,805,731.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,764,400.00	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,437,562.00	115,457,930.60
210201	Тэтгэврийн даатгалын	55,803,381.30	78,687,008.77
210202	Тэтгэмжийн даатгалын	6,565,082.59	9,228,103.92
210203	ҮОМШӨ-ий даатгалын	5,174,747.23	7,369,163.14
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,263,150.09	1,851,831.96
210205	Эрүүл мэндийн даатгалын	12,631,200.79	18,321,822.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,833,368.00	45,340,592.19
210301	Гэрэл цахилгааны зардал	5,457,246.00	8,717,729.09

210302	Түлш, халаалтын зардал	21,088,688.00	25,527,516.78
210303	Цэвэр бохир усны зардал	12,287,434.00	11,095,346.32
210304	Байрны түрээс		
2105	Нормативт зардал	107,592,914.00	157,087,807.34
210501	Эм	-	
210502	Хоол, хүнс	107,592,914.00	157,087,807.34
210503	Нормын хувцас		
2106	Эд хогшил урсгал засвар	4,000,000.00	2,312,500.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	2,312,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	
210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,220,000.00	2,426,700.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,220,000.00	2,426,700.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,932,740.00	53,141,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,143,940.00	45,861,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	9,788,800.00	7,280,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,803,332.00	15,783,307.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,337,200.00	15,773,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,337,200.00	15,773,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	466,132.00	9,907.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	466,132.00	9,907.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	16,196,689.24	107,027,981.92
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	7,646,100.00	14,824,450.00
22	Хөрөнгийн зардал	7,646,100.00	14,824,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,646,100.00	14,824,450.00
223001	Бусад хөрөнгө	7,646,100.00	14,824,450.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,646,100.00)	(14,824,450.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	8,550,589.24	92,203,531.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,550,589.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,550,589.24	100,754,121.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	651,359,436.74	856,361,589.31	1,802,857,026.05
НББ-ийн бодлогын өөрчлөлт			(2,659,218,615.36)	(2,659,218,615.36)
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(651,359,436.74)		(651,359,436.74)
ҮХ-ийн өсөлт, бууралт	1,507,721,026.05	-		1,507,721,026.05
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			1,907,005,113.53	1,907,005,113.53
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	651,359,436.74	960,509,676.79	1,907,005,113.53
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			200,511,549.30	200,511,549.30
2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	651,359,436.74	1,161,021,226.09	2,107,516,662.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хуви
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,394,052,200.00	1,272,024,660.27	(122,027,539.73)	91.2
21	Урсгал зардлын дүн	1,394,052,200.00	1,273,644,660.27	(120,407,539.73)	91.4
210	Бараа үйлчилгээний зардал	1,378,278,800.00	1,257,871,260.27	(120,407,539.73)	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	954,709,400.00	865,660,180.14	(89,049,219.86)	90.7
210101	Үндсэн цалин	616,105,000.00	597,652,441.79	(18,452,558.21)	97.0
210102	Нэмэгдэл	305,744,900.00	237,202,007.35	(68,542,892.65)	77.6
210104	Урамшуулал	32,859,500.00	30,805,731.00	(2,053,769.00)	93.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,375,600.00	115,457,930.60	(2,917,669.40)	97.5
210201	Тэтгэврийн даатгал	80,495,000.00	78,687,008.77	(1,807,991.23)	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	9,470,300.00	9,228,103.92	(242,196.08)	97.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,576,100.00	7,369,163.14	(206,936.86)	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,911,900.00	1,851,831.96	(60,068.04)	96.9
210205	ЭМД-ын хураамж	18,922,300.00	18,321,822.81	(600,477.19)	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,976,000.00	45,340,592.19	(23,635,407.81)	65.7
210301	Гэрэл цахилгааны зардал	20,900,000.00	8,717,729.09	(12,182,270.91)	41.7
210302	Түлш, халаалтын зардал	34,000,000.00	25,527,516.78	(8,472,483.22)	75.1
210304	Цэвэр бохир усны зардал	14,076,000.00	11,095,346.32	(2,980,653.68)	78.8
210303	Байрны түрээс			-	
2105	Нормативт зардал	163,160,800.00	157,087,807.34	(6,072,992.66)	96.3
210501	Эм			-	
210502	Хоол хүнс	163,160,800.00	157,087,807.34	(6,072,992.66)	96.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,312,500.00	2,312,500.00	
210604	Урсгал засвар		2,312,500.00	2,312,500.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,426,700.00	2,426,700.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,426,700.00	2,426,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,630,300.00	69,585,550.00	(1,044,750.00)	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,350,300.00	60,720,550.00	(2,629,750.00)	95.8

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,280,000.00	8,865,000.00	1,585,000.00	121.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,773,400.00	15,773,400.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,773,400.00	15,773,400.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	15,773,400.00	15,773,400.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	(1,620,000.00)	(1,620,000.00)	
	Дотоод эх үүсвэрээр		(1,620,000.00)	(1,620,000.00)	
	Тоног төхөөрөмж			-	
	Бусад хөрөнгө		(1,620,000.00)	(1,620,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,394,052,200.00	1,364,228,192.19	(29,824,007.81)	97.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,273,590,700.00	1,265,040,100.00	(8,550,600.00)	99.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,273,590,700.00	1,265,040,100.00	(8,550,600.00)	99.3
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,926,500.00	47,653,092.19	(21,273,407.81)	69.1
132001	Орон нутгийн төсвөөс	68,926,500.00	47,653,092.19	(21,273,407.81)	69.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	51,535,000.00	51,535,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,535,000.00	51,535,000.00	-	100.0
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	
120002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих			-	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			-	
31	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		8,550,589.24	8,550,589.24	
31	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		100,754,121.16	100,754,121.16	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51.00	51.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	44.00	44.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0
032	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч				
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч				

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7-р цэцэрлэг нь *“Бага насны хүүхдэд боловсролын үр өгөөжийг тэгш хүртээгч, багшлахуй суралцахуйн жор баригч байна.”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах Стратегийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж цэцэрлэгийн менежментийг сайжруулах
- Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөх
- Чанартай боловсрол олгох замаар байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Тасралтгүй хөгжүүлэх сургалтын тогтолцоо арга зүйг нэвтрүүлэх
- Орчин үеийн шаардлагад нийцэхүйц сургалтын орчныг бүрдүүлэх
- Багш нарын тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх
- Гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Багш ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулах

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж

эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 200,511.5 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үндэслэл	Эцсийн үндэслэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,550.6	100,754.1-	92,203.5
Авлага	-	-	-
Бараа материал	102,962.7	138,122.5	35,159.8
Үндсэн хөрөнгө	1,795,491.8	1,868,640.0	73,148.2
Нийт хөрөнгө	1,907,005.1	2,107,516.6	200,511.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,907,005.1	2,107,516.6	200,511.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,907,005.1	2,107,516.6	200,511.5

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 100,754.1 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 138,122.5 мянган төгрөг болж 35,159.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 199,636.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар Дээрэт ОУЭБ-ын байгууллагаас 9,270.0 мянган төгрөг, Тэгш хамруулах боловсролыг дэмжих төслөөс 21,126.4 мянган төгрөгийн бараа материал тус тус хүлээн авч, үйл ажиллагаанд 194,873.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,868,640.0 мянган төгрөг болж 73,148.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар Дархан сумын ОНХС-аас сувиллын зусланд хүүхдийн модон ор 17,500.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зусланд үндсэн хөрөнгөд 7,880.7 мянга, иргэний хандиваар 7,400.0 мянга, тэгш хамруулах боловсролыг дэмжих төслөөр 138,316.6 мянган төгрөг, гадаадын хандив тусламжаар 20,225.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 13,444.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, өөрийн орлогоор 3,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орлогод

авсан, тайлант онд 129,488.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,107,516.6 мянган төгрөг болж 200,511.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2023 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,348,265.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,177.6 мянган төгрөг нийт 1,423,383.5 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 83,225.8 мянган төгрөгөөр бууруулж 1,265,040.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 71,645.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 44,307.6 мянга, хоол хүнсний зардал 43,142.9 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Тайлант онд нийт батлагдсан төсвийг 408,913.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 296,724.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 36,127.5 мянга, хүүхдийн хоол хүнсний зардлыг 33,080.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 42,980.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,273,590.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 68,926.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 51,535.0 мянган төгрөг нийт 1,394,052.2 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 47,663.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 47,653.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 9.9 мянга төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс 1,265,040.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,164,286.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 100,754.1 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,272,034.6 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 100,754.1 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол	1,394,052.20	1,272,024.70	(122,027.50)	91.2

1.1	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,640.00	1,213.00	(2,427.00)	33.3
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	134,699.20	134,149.81	(549.39)	99.6
1.3	81834- Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	948,520.20	872,507.83	(76,012.37)	92.0
1.4	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	263,090.30	220,051.56	(43,038.74)	83.6
1.5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	6,093.50	6,093.50	-	100.0
2.1	81823-Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	3,640.00	3,640.00	-	100.0
2.2	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчин сайжруулах	32,000.00	32,000.00	-	100.0
3.1	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөнөөс хуваарилсан	2,369.00	2,369.00	-	100.0
Нийт дүн		1,394,052.20	1,272,024.70	(122,027.50)	91.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа, үйлчилгээний төлбөр тооцоо, цалин хөлсний зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "ЦЭСБ-Аудит" ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Э.Эрдэнэбат, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 640,447.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,404.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2023 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалингийн зардлыг 89,049.2 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 2,917.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,635.3 мянга, хоол хүнсний зардал 6,073.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 176.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 398.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	176.5	1	176.5	100
Зөвлөмж	1	398.8	1	398.8	100
Нийт дүн	2	575.3	2	575.3	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,746.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 219.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,527.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт Тус цэцэрлэгийн 2 ажилтныг 11 дүгээр сард үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэлд 219.6 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаалын 7 дахь заалтад "Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

5.3.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

5.3.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 500.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

5.3.1.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах.

5.3.2 Цалин хөлстэй холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт: Тайланд онд санхүүгийн орлого үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшлуулалын зардлыг 2,027.0 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7. “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах,” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.3.1.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайланд онд санхүүгийн орлого үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардлыг дутуу тооцсон байна.	1	2,027.0					1	2,027.0				
Нийт худалдан авалтыг анхан шатны баримттай тулган шалгахад худалдан авалтын болон ибаримтын анхан шатны баримт зөрүүтэй байна.	1	500.0					1	500.0				
Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996.04.20-ны өдрийн 63/104 дүгээр тушаалд заасны дагуу үр чадварыг үнэлж дүгнээгүй байна.	1	219.6	1	219.6								
Дүн	3	2,746.6	1	219.6	-	-	2	2,527.0	-	-	-	-